

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ “ХОТЫН СОЁЛ” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2021 оны 09 дүгээр сарын 25

Багануур дүүрэг

1. Байгууллагын соёл, албан хаагчдын ёс зүйн хандлага, харилцааны соёлыг төлөвшүүлэх чиглэлээр дотооддоо сургалт зохион байгуулах, иргэдэд үзүүлж буй үйлчилгээндээ чирэгдэлгүй түргэн шуурхай байх

09 дүгээр сарын 06-13-ны өдрүүдэд “Монгол өв соёл” үндэсний соёл уламжлалаа сурталчлах 7 хоногийн аян өрнүүлж фейсбүүк хуудасны “Эх хэл соёл” группт хамт олноороо нэгдэн мэдээллийг түгээн дэлгэрүүлсэн. Хуваалцсан мэдээллийн тоо – 18, мэдээллийг уншсан хүний тоо – 154

Хөрөнгө оруулагчид, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг цахимаар хүлээн авч, шаардлагатай мэдээ, мэдээллийг өдөрт нь, судалгааны чиглэлийн мэдээ мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан шуурхай хүргэн ажилладаг.

Байгууллагын албан хаагчид Соёлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган соёлын талаарх иргэний үүргээ биелүүлэн ажиллаж байна.

2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газраас бэлтгэсэн соён гэгээрүүлэх нөлөөллийн контент, нэвтрүүлэг, зурагт хуудсыг байгууллагын олон нийтийн сүлжээний цахим хуудас болон албан хаагчдын хувийн фейсбүүк хуудсаар дамжуулан сурталчлах, давалгаалуулах ажлыг зохион байгуулах

Нийслэлийн Соёл, урлагийн газар фейсбүүк хуудсанд тавигдсан “Хот” цуврал нэвтрүүлэг, “Булаг 21” Арт кемп үзэсгэлэн, “Амдрах орчны соёл”, “Номын баяр” “Улаанбаатар хотын музейн тулгамдаж буй асуудал”, “Урлагийн хот Улаанбаатар аян”, “Үзвэр үйлчилгээний соёл”, зэрэг мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж байна. Цахим хуудаснаас мэдээллийг уншсан тоо - 54



3. Аяны хүрээнд шинээр ажил санаачлан олон нийтэд сурталчлах

“Хувийн соёлоос нийтийн соёл, Нийтийн соёлоос хотын соёл” уриалгыг гарган байгууллагын цахим хуудсанд байршуулж иргэдийг уриалж байна. Цахим хуудаснаас мэдээллийг уншсан тоо – 54



Хувийн соёл – Нийтийн соёл
Нийтийн соёлоос Хотын соёл
Соёлтой хотыг бий болгоё.

Мөн дээрх уриалгаар тусгай фрем бэлтгэн фейсбүүк хуудсанд давалгаалуулах ажлыг зохион байгуулсан. Давалгаалсан хүний тоо - 28



ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:
МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА,
ХОТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ч. Баярцэцэг

Ч.БАЯРЦЭЦЭГ